

**“ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ, ЖАГСААЛТ, ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ”
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2024 оны 01 дүгээр сарын 19

Удиртгал хэсэг.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.8-т зааснаар “ЭМДҮЗ нь эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах” үүрэгтэй бөгөөд уг хуулийн заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоолын төслийг боловсруулан санал авахаар танилцуулж байна.

Эрүүл мэндийн мэндийн салбарт хэрэгжүүлж буй санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд 2020, 2021, 2022, 2023 онуудад эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн баталж мөрдүүлсэн бөгөөд энэ удаад 5 дахь өөрчлөлтийн хувилбарыг боловсруулан танилцуулж байна. Энэхүү тогтоолын төслийг боловсруулах хүрээнд дараах үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн тогтоолоор 2024 оны 4 дүгээр сарын 1-ны өдрөөс цалин хөлс, орон нутгийн нэмэгдэл хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотой холбогдох тооцооллыг эрүүл мэндийн байгууллага бүрээр гаргаж ажиллалаа.
2. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг шинэчлэн боловсруулах санал тооцоо, судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/400 дугаар тушаалаар байгуулагдсан бөгөөд уг ажлын хэсгийн хурлаар эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэг, төлбөрийн хэмжээ, тоо хэмжээний өсөлт, холбогдох бодлогын тохируулга хийх хувилбаруудыг гаргаж хэлэлцүүллээ.
3. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх явцад эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн тулгамдсан асуудлыг нэгтгэж, асуудлыг шийдвэрлэх шийдлийн хувилбаруудыг тодорхойлж, энэхүү тогтоол болон ЭМС-ын тушаалаар шийдэгдэх асуудлыг ангилж, хийх ажлын жагсаалт, тэдгээрийг хэрэгжүүлэх байгууллагуудыг тодорхойлон, холбогдох талуудад үүрэг болгосны дагуу энэхүү тогтоолын төслийг боловсрууллаа.

Жагсаалт, журмыг шинэчлэн боловсруулахдаа эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны батлагдсан төсөвт багтаан үр ашигтай зохион байгуулах, даатгуулагчдын

амь насыг аврах, санхүүгийн эрсдэлээс хамгаалах, салбарын үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэж стратегийн худалдан авалтын бодлогыг тусгаж амбулаторийн тусламж, үйлчилгээ, эрчимт эмчилгээ, мэс засал, хурц үеийн эмийн эмчилгээ, эх, хүүхдийн эрүүл мэнд, сэргээн засах зэрэг салбарын тэргүүлэх чиглэлд онцгой анхаарч нэмэлт, өөрчлөлтийг тусгасан болно.

ЭМД-ын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, холбогдох журмыг шинэчлэх үндэслэл шаардлага, шинэчилсэн тогтоолд тусгагдсан гол өөрчлөлтүүд;

Энэхүү тогтоолын шинэчлэлийн гол зорилго нь иргэн даатгуулагчийн асуудлыг иж бүрэн цогцоор шийдвэрлэж буй байдалд анхаарч, гүйцэтгэл, үр дүнг хянаж санхүүжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд дараах өөрчлөлтүүдийг тусламж, үйлчилгээний багцад оруулсан. Үүнд:

- Оношийн хамааралтай бүлгийн суурь тарифийг тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэлтэй уялдуулан дараах байдлаар нэмэгдүүлсэн. Үүнд
 - УИХ-аас баталсан МУ-ын 2024 оны төсвийн тухай хуулийн дагуу 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн төрийн албан хаагчын цалин урамшууллагыг нэмэгдүүлэх, орон нутагт ажиллаж буй иргэдийн цалингийн нэмэгдэл хөлсийг суурь тариф болон цалингийн индексээр тохируулж тооцооллыг хийсэн.
 - Амбулаторийн тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээг дэмжиж шаардлагагүй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг бууруулах бодлого баримталсны дагуу тодорхой үр дүн гарсан бөгөөд харин амбулаторийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, иргэн төвтэй болгох үүднээс тусламж, үйлчилгээг багцалсан
 - Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний өртгүүдийг дахин тооцоолж, оношийн хамааралтай бүлгүүдийг дахин шинэчлэн, нэгтгэн, өөрчлөн зохион байгуулах ажлуудыг хийж байна.
- Амбулаторийн тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлэгт өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг тохиолдол тус бүрээр санхүүжүүлдэг байсан нь эрүүл мэндийн байгууллагуудад тоо хэмжээ хөөх сонирхолыг өдөөж байсан тул оношийн хамааралтай бүлгийн зарчмын дагуу тухайн тусламж, үйлчилгээг цогцоор нь үзүүлэх зарчмыг баримталж шинээр амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээг нэгтгэн шинээр багц үүсгэсэн. Ингэснээр эрүүл мэндийн байгууллагад иргэн даатгуулагчдад амбулаторийн тусламж, үйлчилгээг иж бүрэн цогцоор нь үзүүлж, гүйцэтгэлд нь чанар төлбөрийн хяналт тавьж санхүүжүүлэх боломжийг бүрдүүлсэн.
- ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолын хүрээнд хүн амын өвчлөлийн диспансерийн хяналтын бодлогыг дэмжиж амбулаторийн тусламж, үйлчилгээний хяналтын үзлэгийг багцыг төрөлжүүлэн өргөжүүлсэн боловч тухайн тусламж,

үйлчилгээний хүртээмж хангалтгүй хэвээр байсан байгаа тул тухайн багцыг өргөжүүлж өндөрт өртөгтэй оношилгоо, шинжилгээг нэмэж багцалсан.

- Хорт хавдрын химийн бай эмчилгээнд хэрэглэдэг эм нийлүүлэлтийн монополь байдлаас хамаарч зах зээлийн үнэ тасралтгүй нэмэгдэж байгаа тул тухайн багцаас эмийг салгаж Засгийн газрын тогтоолоор нэг худалдан авагчийн эх үүсвэрээр худалдан авах тогтолцоонд шилжүүлэх замаар санхүүжилтийн үр ашигтай байдлыг дэмжиж бодлогын тохируулга хийж ажилласан.
- Иргэн даатгуулагчийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилго чиглэлтэй уялдуулж диспансерийн хяналтын тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, мөн байнгын эмчийн хяналтад удаан хугацааны нөхөх эмчилгээний эмийн жагсаалтаас хэрэглэсэн эмийг тусад нь санхүүжүүлэхээр заасан.
- Эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг задалж, үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын гүйцэтгэлээр нь 3 ялгаатай оношийн хамааралтай бүлэг болгон хуваасан. Ингэснээр эмнэлзүйн удирдамж зааврын дагуу иргэн, даатгуулагчдад шаардлагатай тусламж, үйлчилгээг иж бүрэн үзүүлсэн байхыг дэмжиж санхүүжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.
- Эрхтэн шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлэгт донор болон реципиентийн эрхтэн шилжүүлэн суулгахын өмнөх оношилгоо шинжилгээний зардал, мэс заслын зардалыг багцаар нь санхүүжүүлж байсан боловч иргэн, даатгуулагчдад иж бүрэн үзүүлэхгүй байсан тул эрхтэн шилжүүлэн суулгахын өмнөх тусламж үйлчилгээний амбулаторийн багц, хэвтүүлэн эмчлэх мэс заслын тусламжийн донор, реципиентийн оношийн хамаралтай бүлэг, эрхтэн шилжүүлэн суулгасаны дараах хяналтын багц гэж задлан тус тус оношийн хамаралтай бүлгийг өргөжүүлсэн.
- Сэргээн засах тусламж үйлчилгээг хурц үеийн тусламж үйлчилгээний дараа авсан тохиолдолд санхүүжүүлэх бөгөөд гарсан үр дүнгээс нь хамаарч санхүүжилтийг үргэлжлүүлэх эсэхийг шийдэж, дэмжиж санхүүжүүлэхээр тус тус зохицуулсан.
- Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.7-т “удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал”-ыг төрөөс хариуцахаар заасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/407 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж энэхүү тогтоолын хавсралтаар төрөөс төлбөрийг 100% хариуцсан санхүүжүүлэх журам, эмийн жагсаалтыг батлуулахаар төсөлд тусгасан.

Иймд ЭМДЕГ-аас Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 –т “Захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авна.” Гэсэн заалтын дагуу санал авахаар байршууллаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР